

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын
2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн
34 дугаартай албан бичгийн 1 дүгээр хавсралт

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ
/2023 оны 01 дүгээр улирлын байдлаар/

2023 оны 03 дугаар сарын 22

Багануур дүүрэг


Д/д	Өргөдөл, гомдлын агуулга	Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэх шатандаа байгаа		Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо					Иргэнд хариу хүргүүлсэн хэлбэр			Өргөдлийн төрөл				
			Шийдвэрлэх хугацаандаа байгаа	Хугацаа хэтэрсэн	1-10 хоногт	11-20 хоногт	21-30 хоногт	Хугацаа сунгасан	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдлийн тоо	Албан бичгээр	Утсаар	Биечлэн уулзах	Талархал	Санал	Хүсэлт	Гомдол	Мэдэгдэл
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
1	Ажил хүссэн																
2	Дэмжлэг туслалцаа хүссэн																
3	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой																
4	Тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдаас гаргасан өргөдөл	1			1							+			+		
5	Иргэдээс байгууллагын ажилтан, албан хаагчидтай холбоотой гаргасан өргөдөл																
6	Бусад																
	Нийт	1			1							1			1		

Өргөдлийн шийдвэрлэлтийн байдал

№	Ангилал	Тсо	Шалтгаан, тайлбар
0	1	2	3
1	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл	1	-
2	Боломжгүй тухай хариу өгсөн	-	-
3	Бусад	-	-

ХЯНАСАН:


ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Д.МӨНХТОГТОХ

ТАЙЛАН ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ГАДААД ХАРИЛЦАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



М.МӨНХДУЛАМ

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-Т ИРГЭД,
АЛБАН ХААГЧДААС ИРҮҮЛСЭН ӨРГӨДЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2023 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

2023 оны 03 дугаар сарын 22

Багануур дүүрэг

1.Манай байгууллагад 2023 онд 1 албан хаагчаас цалин нэмэгдүүлэх хүсэлт гаргаж өргөдөл ирүүлсэн нь өмнөх оны тухайн үеийнхээс төрлийн хувьд харьцуулах боломжгүй, тооны хувьд илүү байна.

Өргөдлийг өдөрт нь албан хаагчийн хүсэлт ёсоор, “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын даргын тушаалаар шийдвэрлэсэн. 2022 оны 01 дүгээр улиралд манай байгууллагад өргөдөл ирээгүй байна.

Тайлант хугацаанд албан хаагчаас ирүүлсэн 1 өргөдлийг ERP системийн Өргөдөл, гомдол дэд хэсэгт бүртгэж, өргөдөл хяналтын картыг хөтөлж, өргөдөл болон өргөдөл хяналтын картаар хадгаламжийн нэгж үүсгэн архивлахад бэлтгэв.

Өргөдлийг хамгийн боломжит богино хугацаанд шийдвэрлэхийг зорьж байгаа ба ажлын 1 өдрийн дотор шийдвэрлэж байна.

2.Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй.

3.Бүтээлч санал санаачилгын шинжтэй хүсэлт илэрхийлж, мэдээлэл хүссэн иргэдтэй байгууллагын удирдлага биечлэн уулзаж, Паркийн зорилго чиглэл, үйл ажиллагааны тухай тодорхой мэдээлэл, зөвлөгөө, чиглэл өгч ажилладаг. Энэ уулзалтын бүртгэлийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд улирал бүр албан бичгээр хүргүүлдэг. 2023 оны 01 дүгээр улирлын байдлаар байгууллагын удирдлага нийт 6 иргэнтэй уулзсан байна.


3.1.Иргэд, аж ахуйн нэгжээс гаргасан бүтээлч санал санаачлагын хүсэлтийг Паркийн үйл ажиллагаатай уялдуулан нааштайгаар шийдвэрлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах зорилгыг хэрэгжүүлж ажилладаг. Тухайлбал, Багануур дүүрэгт төмрийн үйлдвэр барих төсөл хэрэгжүүлж байгаа МЕСЕС ХХК-тай 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулсан. МЕСЕС ХХК-тай хамтран хэрэгжүүлэх Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 6,76км урт 110кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугамыг барих ажлын нийт 3,922.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 45%-ийг тус компаниас, 55%-ийг нийслэлийн төсвөөс шийдвэрлүүлэхээр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт талаас уг ажлыг гүйцэтгэх бэлтгэл ажлыг ханган ажилласан. Улмаар МЕСЕС ХХК-ийн зүгээс 526,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар суурийн барилгын ажил хийх хүрээнд 500.0 сая төгрөгийн бетон болон төмөр тулгуур бэлтгэх ажил хийгдээд байна.

3.2.“Импактор Капитал Менежмент Монголия” ХХК-иас Паркийн хүрээнд, уурхайн хаягдал нүүрсийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслийн санал ирүүлснээр Паркийн Хүнд үйлдвэрлэлийн бүсэд Казахстан, Герман, Монгол Улсын хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэх “Импактор Капитал Менежмент Монголия” ХХК-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд цахим болон нүүр тулсан уулзалтууд зохион байгуулж, уг төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын талаар зөвшилцсөн. Төсөл хэрэгжүүлэх хүрээнд Казахстан Улсаас инженерийн баг ирж Улаанбаатар хотод ажилласан. 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр төслийн баг Багануур үйлдвэрлэл, технологийн паркад ирж ажиллана.

4.Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, тайланг байгууллагын цахим хуудасны ил тод байдал хэсэгт улирал бүр нээлттэй байршуулан ажиллаж байна.


5.Иргэдээс манай байгууллагын ажилтан, албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой гаргасан өргөдөл, гомдол байхгүй.

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Д.МӨНХТОГТОХ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ГАДААД ХАРИЛЦАА, БИЧИГ ХЭРЭГ, АРХИВ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



М.МӨНХДУЛАМ